



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 0/419

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аюулгүй нөөцөд ногоон тэжээл (овьёос) бэлтгэх зорилгоор 20,000,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 20,000,000 төгрөг (хорин сая)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дугаар хуралдааны 7/02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 3.3 дахь заалт, аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



**АЮУЛГҮЙН НӨӨЦӨД НОГООН ТЭЖЭЭЛ (ОВЬЁОС) БЭЛТГЭХ  
ЗАРДЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА**

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт дүн
1	Ногоон тэжээл (овьёос)	боодол	1600 боодол	12 500	20 000 000
Нийт дүн					20 000 000

-оОо-